



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, 79 зүйлийн 79.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дархан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1. "Дархан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Баясгалан нь эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул үүрэгт ажлаас чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс тасалбар болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах;

1.2. Зам, тээврийн сайдын 2023 оны 01/3280 дугаар албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2023 оны "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 2023 оны 05/12788 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн "Дархан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Б.Батболдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу түр томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ